



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

“МИК Актив Хоёр” ХХК-ийн
гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.1 дэх дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “МИК Актив Хоёр” ХХК-ийн гаргаж буй нэг бүрийн 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 20 хүртэл жилийн хугацаатай, нийт 2,248,362 /хоёр сая хоёр зуун дөчин найман мянга гурван зуун жаран хоёр/ ширхэг хүртэл орон сууцны зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаасыг доорх хэлбэр, нөхцөлтэйгөөр үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, төвлөрсөн хадгаламжид бүртгэж, холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэж ажиллахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай:

Баталгаат үнэт цаасны төрөл	Нэрлэсэн үнэ	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ
Энгийн баталгаат үнэт цаас	100,000	224,837	10,5%	20 хүртэл жил	22,483,700,000
Давуу эрхтэй баталгаат үнэт цаас	100,000	2,023,525	4,5%	20 хүртэл жил	202,352,500,000
Нийт	100,000	2,248,362			224,836,200,000

2. Үнэт цаасны танилцуулгад тусгасан **2,248,362** ширхэг хүртэл баталгаат үнэт цаасыг энэ тогтоолын 1-д заасан хэмжээгээр үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хооронд байгуулсан гэрээний дагуу худалдахыг “МИК Актив Хоёр” ХХК-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “МИК Актив Хоёр” ХХК-д үүрэг болгосугай:

1/ Санхүүгийн зохицуулах хороо нь энэхүү тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэн нь тухайн үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багцад байгаа үл хөдлөх хөрөнгийн жагсаалтад байгаа мэдээлэл нь эрсдэлгүй, үнэн зөв гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв тухайн баталгаат үнэт цаасанд эрсдэл гарвал Санхүүгийн зохицуулах хороо хариуцахгүйг

000251

мэдэгдэхийн хамт энэ талаар үнэт цаасны танилцуулгад тусгайлан тэмдэглэж хөрөнгө оруулагчдад мэдээлэх;

2/ Энэ тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан уг үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багц дахь үл хөдлөх хөрөнгийг Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн хамтарсан А/167/203 тоот тушаалаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийх бүртгэх тухай журам”-д заасны дагуу Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн байгууллага дахь барьцааны бүртэлд бүртгүүлж, энэ талаар ажлын 10 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд эргэж мэдэгдэх;

3/ Баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг 30 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөр төлөх, мэдээллээр хангах болон бусад үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллах.

4. Баталгаат үнэт цаасны борлуулалт, үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж, энэ талаар улирал бүр Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлж ажиллахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН